**Самбар 16** **Монгол орны мод сөөг** Эмхэтгэсэн: Манфред Веспер, Любек

## Wildapfel | Алим | Malus baccata

Герман нэршил

Монгол нэршил
Монголд 1 зүйл

Латин нэршил





**Тодорхойлолт:**

Дундаж өндөр 5 метр, навч нь өндөг хэлбэрийн үзүүр рүүгээ үл мэдэг нарийссан. Ягаавтар туяатай цагаан цэцэгтэй ба цэцгийн шүүс нь шавжны хоол болдог. Жимс нь бөөрөнхий, голч нь 10 мм орчим, шар буюу улбар шар өнгөтэй байна. Жимс нь исгэлэн, гашуун тул хүнсэнд хэрэглэдэггүй. Хот суурин газарт тарихад маш тохиромжтой. Улаанбаатар хотын гудамжинд олноор харагддаг. Үрээр тарина.

**Мэдээлэл:** Хэмжээний хувьд жижгэвтэр алимны модыг цэцэрлэг, хүрээлэнгүүдэд тарихад нэн тохиромжтой. Орчин харгалзахгүй ургана. Усалгааг орхигдуулж болохгүй!

**Грайфсвалдын Их Сургуулийн гербари** http://greif.uni-greifswald.de/floragreif/?flora_search=Taxon&taxon_id=2556

Дэлгэрэнгүй мэдээлэл, тархалтын зураг болон бусад зургуудтай дээрх холбоосоор орж танилцана уу.